# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.12.25

**УРИА:** ХҮНДЭЛЬЕ, СОНСЪЁ, ХАМТАРЪЯ.

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Цусны салбар төв байгуулна. | -Шинээр байгуулагдсан Цусны салбар төв<br>-Төлөвлөгөөний биелэлт | Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн Цусны салбар төвөөс цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэж, эмнэлгийн хэрэглээг хангаж байсан. | Цусны салбар төвийг шинээр байгуулж, сургалт зохион байгуулан, мэргэжил арга зүгээр хангасан байна. Салбар төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж шаардлагатай цус цусан бүтээгдэхүүнээр эмнэлгийн захиалгыг бүрэн хангаж ажилласан байна. | I-IV улирал | Дорноговь аймгийн Замын-үүд сумын Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 3 сард цусны салбар төв шинээр байгуулагдсан. ЦССҮТ-өөс томилогдсон 5 эмч, мэргэжилтэн Дорноговь аймгийн ЭМГ, НЭ-тэй хамтран 2025 оны 4 сард дараах чиглэлээр мэргэжил арга зүйгээр ханган, цусны салбар төвийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлсэн. Үүнд:<br>● ЦСТ-т суурилуулсан бүх тоног төхөөрөмжид үзлэг хийн, шалгалт тохируулга, үйл ажиллагааны хяналтыг хийж, сийвэн цуглуулах аппаратыг бүрэн ажиллагаанд оруулсан.<br>● ЦСТ-ийн үндсэн үйл ажиллагааны цахим программын үйл явцын урсгалын дагуу нээж, ЦЦБ үйлдвэрлэлийн программуудыг суулган, ажиллах эмч, мэргэжилтэнг сургасан.<br>● Цусны донор сонгох, эрүүл мэндийн үзлэг хийх, цус, сийвэн цуглуулах, ЦЦБ-ий үйлдвэрлэл, хорио, хадгалалт, халдвар илрүүлэх шинжилгээний хариу илгээх, хориооноос чөлөөлөх үйл ажиллагааг бүрэн хийх боломжтой болгосон.<br>● 8 нэр төрлийн 29 нэгж ЦЦБ үйлдвэрлэж, ЦЦБ-ийн үйлдвэрлэлийн ажлын байран дээрхи сургалт зохион байгуулсан.<br>● Нэгдсэн эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд цусны аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг хэвшүүлэх чиглэлээр 4 сэдвээр сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 97 ажилтан хамрагдсан.<br>● Нэгдсэн эмнэлэг, ЦСТ-д дэмжлэгт үнэлгээ хийж ЦСТ-ийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах 7 чиглэлийн хүрээнд 53 зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Цус цуглуулах суурин төв шинээр байгуулна. | -Байгуулсан шинэ төв<br>-Цус цуглуулалтын тоо, хувь | 2024 оны төсвийн төсөл, ЭМЯ-ны хөгжлийн бодлогод тусгуулахаар санал хүргүүлсэн. | Сонгинохайрхан, Хан-Уул дүүргээс сонгон цус цуглуулах суурин төв шинээр нээж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна. | II-IV улирал | Цус цуглуулах суурин төв шинээр байгуулахад шаардлагатай өрөө, талбайн хэмжээг тооцож БГД-ийн ИТХ, ЗДТГ, ТЗНЭ-үүдэд байрны дэмжлэг үзүүлэх албан тоот хүргүүлж уулзалт хийсэн. ТЗНЭ-ийн удирдлага өрөө санал болгож, Хотын баруун талд БГД, ХУД, СХД-үүдэд зам дагуу, автобус нийтийн унаанд ойр, автомашины зогсоол хүртээмжтэй байх, нийтийн худалдаа, нэг цэгийн үйлчилгээтэй ойр зэрэг нийтлэг шалгуурыг хангасан байхаар газарт шийдвэрлүүлэх дэмжлэг хүссэн. БГД-ийн ИТХ судлаад дэмжиж, хамтарч ажиллахаар урьдчилсан байдлаар тохирсон. Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, удирдах, гүйцэтгэх албан тушаалын зохистой харьцааг бүрдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, захиргааны нүсэр бүтцийг багасгаж ажиллах тухай ЭМС-ын 2025 оны 06 сарын 25-ний өдрийн 1а/3266, 2025 оны 07 сарын 22-ны өдрийн 1а/3546 албан  албан бичгийн хэрэгжилтийн хүрээнд 2025 онд шинэ төв байгуулах төлөвлөгөөт ажлыг түр хойшлуулсан. | 70% |
| 3. | “Амбулаториор үнэ төлбөргүй олгогдох гемофилийн эсрэг факторын хангамж, түгээлтийг зохицуулах журам”-ыг шинэчлэн боловсруулна. | -Шинэчлэн боловсруулж хүргүүлсэн журмын төсөл | Эрүүл мэндийн сайдын 2013 оны 37 тоот тушаалыг мөрдөж байна. | Гемофилийн эмгэгтэй үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2013 оны 37 тоот тушаалаар батлагдсан “Амбулаториор үнэ төлбөргүй олгогдох гемофилийн эсрэг факторын хангамж, түгээлтийг зохицуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж төслийг ЭМЯ-д хүргүүлсэн байна. | II-III улирал | Төвийн захирлын 2025 оны 03 сарын 17-ны А/17 тушаалын 3 дугаар хавсралтаар Эрүүл мэндийн сайдын 2013 оны 37 тоот тушаалыг шинэчлэх төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлыг хэсэг  2025 оны 4 сарын 18-ны өдөр гемофилийн тусламж үйлчилгээг амбулаториор үзүүлэх өнөөгийн нөхцөл байдлаар МҮГХ, ЭХЭМҮТ, УНТЭ, АШУҮИС-ийн Монгол Японы эмнэлгийн эмч мэрэгжилтнүүдтэй уулзалт хийж, санал солилцон, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 37 тоот тушаалд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцсэн. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, журмын төслийг боловсруулан 2025 оны 12 сард ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>Мөн гемофилийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор гемофилийн эсрэг факторын захиалга болон олголт, нөөц, тайлангийн цахим хөгжүүлэлтийг ЭМХ-тэй хамтран нэвтрүүлэхээр ажиллаж байна. | 100% |
| 4. | Молекул биологи, иммунологи, иммуногематологи, чиглэлээр олон улсын чанарын гадаад үнэлгээнд хамрагдана. | -Шинжилгээний чиглэл тус бүрээр чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан дүн<br>-Баталгаажилтын гэрчилгээ | 2024 онд иммуногематологийн шинжилгээгээр 4 удаа, Молекул биологийн шинжилгээгээр 3 удаа, иммунологийн шинжилгээний 2 аргаар тус бүр 3 удаа тус тус ОУ-ын чанарын | Молекул биологи, иммунологи, иммуногематологийн чиглэлээр гадаад үнэлгээнд  тус бүр 3 удаа хамрагдаж лабораторийн шинжилгээний  чанарын баталгааг хангасан байна. | I-IV улирал | Тус төв нь доор 3 чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан. Үүнд:<br>-**Молекул биологийн чиглэлээр** B,C гепатит, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээгээр 2025.04 сар, 7 сар, 10 сард нийт 3 удаа Австралийн NRL лавлагаа лабораторийн чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт 100%-ийн үр дүнтэй хамрагдсан.<br>-**Иммуногематологийн чиглэлээр** Австралийн RCPAQAP хяналтанд 8 үзүүлэлтээр 3 удаа 100% үр дүнтэй хамрагдсан.<br>-**Иммунологийн чиглэлээр** RQAS-ийн гадаад хяналтанд 4 удаа оролцож үр дүн 100% тохирсон.<br>-Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт оролцсон чиглэл тус бүрээр хяналтын үр дүнгийн хуудас болон үнэлгээнд оролцсоныг батаалгаажуулсан сертификатыг авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гадаад үнэлгээнд хамрагдсан. | | | | |
| 5. | Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын чиглэлээр үндэсний чанарын гадаад үнэлгээнд хамрагдана. | -Шинжилгээний чиглэл тус бүрээр чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан дүн<br>-Баталгаажилтын гэрчилгээ | 2024 онд Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд тус бүр 2 удаа хамрагдсан. | Гематологи, биохими, нян судлалын шинжилгээний чиглэлээр тус бүр 1-ээс доошгүй удаа чанарын гадаад үнэлгээнд хамрагдаж лабораторийн шинжилгээний чанарын баталгааг хангасан байна. | I-IV улирал | 2025 онд 2 удаа Үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр явагдсан.<br>● 5 сарын 28-нд Гематологи, бүлэгнэлтийн чиглэлээр үндэсний чанарын гадаад үнэлгээ зохион байгуулагдсан.<br>**-Гематологийн чиглэлээр** 2 анализатороор оролцсон. Sysmex XQ-320 аппаратаар оролцож 90,0% үнэлгээ, Mindray BC-780 аппаратаар оролцож 85,83% үнэлгээ тус тус авсан.<br>-**Бүлэгнэлтийн чиглэлээр** Үндэсний чанарын гадаад үнэлгээнд 1 удаа оролцож 96,67% үнэлгээтэй бүх үзүүлэлтэнд бүрэн хамрагдаж оролцсон байна.<br>● 12 сарын 2-нд Гематологи, биохими, бүлэгнэлтийн чиглэлээр оролцсон. Энэ удаагийн үр дүн гараагүй байна.<br>**-Нян судлалын чиглэлээр** Лаборатори хоорондын харьцуулалт хийсэн. УХТЭ-ийн нян судлалын лабораторитой цусны ариун чанар тодорхойлох шинжилгээгээр 2025.09.19-нд хийсэн. Үр дүн 100% тохирсон.<br>**-Ферритин тодорхойлох** шинжилгээгээр 2025.11.11-нд УНТЭ-ийн ЭЭСНЛТ-тай лаборатори хоорондын харьцуулалт хийсэн. Үр дүн 100% тохирсон.<br><br>-Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт оролцсон чиглэл тус бүрээр хяналтын үр дүнгийн хуудас болон үнэлгээнд оролцсоныг батаалгаажуулсан сертификатыг биохими, гематологи, бүлэгнэлтийн чиглэлээр авсан. Нян судлал болон ферритин тодорхойлох шинжилгээгээр лаборатори хоорондын харьцуулалт хийсэн тайлан, дүгнэлт гарсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Цусны бүлэг, хувийн тохирооны Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | -Үнэлгээнд оролцсон лабораторийн тоо, тайлан, -Зохион байгуулсан сургалтын тоо, оролцогчдын тоо | 2024 оны 6, 11 дүгээр саруудад 2 удаа зохион байгуулж нийт 208 лабораторийг хамруулсан. | 23, 24 дэх удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 22, 23 дах удаагийн үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулсан байна. Хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудыг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. | II-III улирал | Үндэсний чанарын гадаад үнэлгээний 22 дахь удаагийн тайлан, семинарыг 2025 оны 3 сарын 21-нд зохион байгуулсан. 22 дахь удаад 106 сорьц тарааснаас хариу ирүүлсэн 86 лабораторит үр дүнг хүргэсэн. 20 лаборатори хариу ирүүлээгүй ба үүний 11 нь цахим программд хариугаа оруулж чадаагүй эсвэл хариу илгээх сүүлийн хугацаанаас хоцорсон бол 9 лаборатори нь бүртгэл үүсгэж эрхээ нээлгээгүй байна.<br>-2025 оны 5 сарын 28-нд 23 дахь удаагийн гадаад хяналтын хөтөлбөрийг зохион байгуулж 118 багц бэлтгэж 118 лабораторит тарааснаас 112 лаборатори хариу ирүүлсэн. 6 лаборатори хариу ирүүлээгүй.<br>2025 оны 09 сарын 26-нд 23 дахь удаагийн үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, оролцогч лабораториудад үр дүнг мэдээлсэн.<br>-24 дэх удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг 12 сарын 2-нд зохион байгуулж, 112 хяналтын багцыг авч, үр дүнгээ ирүүлж байна.<br>-Цусны бүлэг хувийн тохирооны чиглэлээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 70 лабораторийн эмч, мэргэжилтнийг сургасан. | 100% |
| 7. | Цусны салбар төв болон гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад цусны аюулгүй байдлын дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана. | -Дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн байгууллагын тоо, -Тайлан, зөвлөмж | 2024 онд нийт 17 ЦСТ болон гэрээт Эрүүл мэндийн байгууллагад цахим болон ажлын байран дахь дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. | Цусны салбар төв болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд цахим болон ажлын байран дээрх дэмжлэгт хяналт үнэлгээг тус бүр 3-аас доошгүй удаа хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байна. | II-IV улирал | Цусны аюулгүй байдалтай холбоотой Эрүүл мэндийн сайдын тушаалуудын хэрэгжилтийг сайжруулах,, ЭМС-ын 2018 оны А/506 дугаар тушаалыг шинэчлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, эмнэлзүйн зохистой хэрэглээ, зөв дадлыг хэвшүүлэхэд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин туслах зорилгоор Төвийн Ерөнхий захирлын баталсан удирдамжийн дагуу 2025 онд нийт 6 Цусны салбар төв болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд цахим болон ажлын байран дээрх дэмжлэгт хяналт үнэлгээ хийж мэргэжил аргазүйгээр ханган ажилласан байна. Үүнд:<br>Цахим дэмжлэгт үнэлгээнд: Өвөрхангай, Хөвсгөл, Өвөрхангайн Хархорин цусны салбар төв,<br>Ажлын байран дээрх дэмжлэгт үнэлгээнд: , Замын-Үүд ЦСТ, Нийслэлийн өргөө амаржих газар, Нийслэлийн Хүрээ амаржих газарт тус тус хамрагдсан болно. | 100% |
| 8. | Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэх журам боловсруулна. | Боловсруулсан журам | 2024 онд нийт 3 эмнэлэгт нисэгчгүй нисэх төхөөрөмжөөр ЦЦБ-ий тээвэрлэлт хийсэн. | Нисэгчгүй нисэх төхөөрөмжөөр цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэх журмын төсөл боловсруулан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | I-II улирал | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/256 дугаар тушаалын 1-р хавсралт Бүлэг 2-ын 5.Цус цусан бүтээгдэхүүн тээвэрлэх хэсэгт "Эрүүл мэндийн байгууллагуудад цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ автомашин болон зориулалтын дрон ашиглан тээвэрлэж болно." гэсэн заалтыг нэмэлтээр оруулах саналыг 2025 оны 02 сарын 07-нд №41 албан бичгээр ЭМЯ-ын Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт хүргүүлсэн. Дотооддоо журам боловсруулан ажиллах чиглэл өгсний дагуу төвийн захирлын 2025 оны 03 сарын 17-ны А/17 тушаалын тавдугаар хавсралтаар Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр цус, цусан бүтээгдэхүүн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тээвэрлэх журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн 3 удаагийн хурлаар журмын төслийг боловсруулан хэлэлцэн “Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэх журмыг боловсруулан 2025 оны 08 сарын 19-нд төвийн захирлаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | |
| 9. | БСТЗ 1.1.1 Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлж, цус цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулалтыг төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллана. | -Цус цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулалтын тоо | 2024 онд нийт 34256 нэгж цус цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан. | Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлж 35080 нэгж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангасан байна. | I-IV улирал | 2025 онд 35080 нэгж цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулна гэж төлөвлөснөөс 12 сарын 25-ны өдрийн байдлаар 34261 нэгж цус цуглуулж, төлөвлөгөөний биелэлт 97.6%-тай байна. Нийт цуглуулалтын 21048 (61.4%)-ийг суурин хэлбэрээр, 13213 (38.6%)-ийг явуулын хэлбэрээр цуглуулсан байна. 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 2.4%-ийн гүйцэтгэлийн биелүүлэх бүрэн боломжтой. | 100% |
| 10. | 2025 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллана. | -Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо<br>-Борлуулсан бүтээгдэхүүний тоо | 2024 онд нийт 103004 нэгж ЦЦБ үйлдвэрлэж, 62734 нэгж бүтээгдэхүүн эмнэлэгт олгосон байна. | 105000 нэгжээс багагүй ЦЦБ үйлдвэрлэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангасан байна. ЦЦБ-ий борлуулалт өмнөх оны мөн үеэс буураагүй байна. | I-IV улирал | 2025 онд 104,026 нэгж ЦЦБ үйлдвэрлэхээс 104,744 нэгжийг үйлдвэрлэж, төлөвлөгөөний биелэлт 100% байна. 2024 онд 62734 нэгж ЦЦБ борлуулсан бол 2025 оны 12 сарын 25-ний өдрийн байдлаар 61152 нэгж бүтээгдэхүүн борлуулсан байна. | 100% |
| 11. | ЗГМХ 2.3.1.3 Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана. | -Төлөвлөгөө<br>-Тайлан, хэрэгжилтийн хувь | 2024 онд ЭМ-ийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний төвийн чиг үүрэгт хамаарах хэсгийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж батлуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг цаг хугацаанд нь хүргүүлсэн байна. | I-IV улирал | “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын арга хэмжээ 2024-2026 оны төлөвлөгөө”, “Жендэрт суурилсан болон гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ 2024-2027 оны төлөвлөгөө”, Сэтгэцийн эрүүл мэндийн 2024-2027 оны төлөвлөгөө зэрэг хөтөлбөр арга хэмжээний төвийн үндсэн чиг үүрэгт хамаарах зорилго, зорилт, үйл ажиллагааг тусгасан төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Үүнд:<br>-“Байгууллагын хүүхдийн өрөө байгуулж тохижуулах тухай” А/62 дугаар тушаалын дагуу байгууллага 5,2 сая төгрөг, JCI Монгол, JCI Конгресс салбар байгууллагын 10,0 сая төгрөгийн санхүүжилт, төвийн ажилчдын “Сэтгэлийн хандив” нэг сарын аянаар цугларсан тоглоом болон хичээлийн хэрэгсэлээр төвийн хүүхдийн хөгжлийн өрөөг байгуулан тохижуулсан.<br>-Нээлтэд хэвлэл мэдээллийн байгууллага, ивээн тэтгэгч байгууллагын төлөөлөл оролцож, байгууллагын ажилтнуудын хүүхдүүдийн аюулгүй байдал хангагдахаас гадна цусаа өгөх хүсэлтэй боловч хүүхэд харах хүнгүй доноруудад хүүхэдтэйгээ ирээд цус өгөх боломж бүрдсэн талаар нийтэд мэдээлэл түгээсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Ажилтан албан хаагчдынхаа хүүхдийг аав ээжийнх нь ажлын газартай танилцуулах, бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжин ажлын цагийг хорогдуулсан цагаар ажиллуулж, төвийн дотоод групп хуудсаар архи, тамхи., утаат бус электрон тамхины судалгааг танилцуулан 8-17 насны хүүхдүүд хяналтаа сайжруулах талаар 65 хүнд зөвөлгөө хүргэсэн.<br><br>-Эрүүл мэндийн салбарын жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төвийн захирлын А/65 дугаар тушаалаар батлагдсан 3 хүний бүрэлдэхүүнтэй Жендэрийн баг ажилладаг. 2025-2026 оны хичээлийн жилд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил олгох, мэргэжил дээшлүүлэх “Эмнэл зүйн цус сэлбэлт судлал”, “Цус, цусан бүтээгдэхүүний технологи” чиглэлээр элссэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын 4, Улаанбаатар хотын 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд “Жендэрийн тухай ерөнхий ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэлийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” сэдвээр сургалт явуулсан<br>-Жендэрийн Үндэсний хорооноос гаргасан хүчирхийллийн эсрэг зурагт хуудас, мэдээ мэдээллийг Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Амьдрал бэлэглэе пэйж хуудас, Донор та баатар фейсбүүк групп хуудас, төвийн хаалттай группэд байршуулан нийтэд мэдээлэл хүргэсэн.<br>- 1 сарын 30-нд “Ажлын байрны стресс менежмент” сургалтад 56 ажилтан буюу нийт ажилтны 76% нь хамгадсан; 4 сарын 24-нд “Стрессээ эергээр удирдах энгийн арга” сэдэвт сургалтад 42 ажилтан нийт ажилчдын 60% тус тус хамрагдсан. | |
| 12. | БСТЗ 1.1.2<br>Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэнэ. | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэсэн тайлан. | 2024 оны 1 дүгээр сарын 3-нд Цусны донорын Үндэсний өдрийг зохион байгуулж донор алдаршуулсан. | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэж, цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлан, тэднийг алдаршуулсан байна. | I улирал | Цусны донорын Үндэсний өдөр тэмдэглэх удирдамж, төсвийг ерөнхий захирлын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн А/81 дугаар тушаалаар баталж удирдамжийн дагуу МУЗН, МДХ ТББ хамтран зохион байгуулсан. Жил бүрийн 1 дүгээр сарын 3-ны өдөр уламжлал болгон зохион байгуулдаг уг арга хэмжээний гол зорилго нь цусны доноруудыг алдаршуулах, сайн дурын авлагагүй цусны донорын үйлсийг сурталчилах, тогтмол хугацаанд цусаа өгөхийн ач холбогдолыг таниулах бөнөөд энэ жил Мөнгөн донор 2, Хүрэл донор 1, 2024 онд цус цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн хамгийн олон удаа өгсөн 2 донор, нийт 5 донорыг шагнаж алдаршуулсан. МУЗН-ийн “Нигүүлсэл” алтан медалиар 1, “Нигүүлсэл” алт, мөнгөн медалиар тус бүр донор, донорын үйлсийг дэмждэг иргэнийг шагнаж баяр хүргэсэн. 35 ба түүнээс дээш удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн 43 донорт Хүндэт донорын цол тэмдгийг гардуулж баяр хүргэсэн. Шагнагдсан доноруудын төлөөлөл болон анх удаа цусаа өгсөн 12 дугаар ангийн сурагчтай ярилцлага хийж, мэдээлэл бэлтгэн байгууллагын пэйж хуудас, сошиал орчинд болон хэвлэл мэдээллийн байгууллагаар түгээж сурталчилгаа хийсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | БСТЗ 1.1.2 “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг зохион байгуулна. | Цусны донорын Дэлхийн өдрийг зохион байгуулсан тайлан. | 2024 оны 6 сарын 14-нд Цусны донорын Дэлхийн өдрийг Нийслэлийн БЗД-ийн ЗДТГ, ИТХ-ын ажлын албатай хамтран зохион байгуулсан. | ДЭМБ-ын 2025 оны удирдамжийг олон нийтэд сурталчилж, Цусны донорын Дэлхийн өдөр-ийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлсэн байна. | II улирал | ЦДДӨ-ийн арга хэмжээг 2025 оны 06 сарын 14-д **Цусаа өгч, Итгэл түгээе: Хамтдаа амьдрал бэлэглэе!** уриан дор Үндэсний хэмжээнд зохион байгуулсан.<br>-Захирлын 2025 оны 5 сарын 23-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, орчуулга, уриа, ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.<br>-ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт удирдамж, төсөв батлуулан хүргүүлж хамтран ажиллах уулзалт зохион байгуулж, санхүүжилт шийдвэрлүүлсэн.<br>-БГД ИТХ, ЗДТГ хамтран зохион байгуулахаар уулзалт хийж, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах байр, урлагийн номерын зардлыг шийдвэрлэсэн.<br>-Хүндэтгэлийн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө, төсвийг батлуулж батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хүрээнд ЭМЯ, Баянгол дүүргийн ИТХ, ЗДТГ, МУЗН, Мөнгөн гүүр эмнэлэг, Улкер Монголиа байгууллага, Голомт банк, Сүү ХК зэрэг 10-аад байгууллагын хамтын ажиллагаа, дэмжлэгтэйгээр арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан.<br>- Аймгийн Цусны салбар төвүүдэд албан бичиг хүргүүлж арга зүйгээр хангаж ажилласан.<br>- 2025 оны шилдэгүүдийг тодруулж МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар Шударга журам медаль, МУЗН болон ЦССҮТ-ийн шагналаар шагнаж алдаршуулсан.<br>2025 онд Улсын хэмжээнд 35 буюу түүнээс дээш цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн 198 цусны донор Хүндэт донорын болзол хангасны 84 нь Нийслэлээс тодорсон бөгөөд Хүндэт донорын үнэмлэх, тэмдгийг гардуулж баяр хүргэж алдаршуулсан.<br>- 2025 оны ЦДДӨ-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүндэтгэлийн арга хэмжээнд МҮОНТВ, SBN TV, Монгол HD, MNB.mn, Eagl TV8, ТВ-9, “Өнөөдөр” сонин, News.mn, Unuudur.mn, Gogo.mn, Mnb.mn, Ikon.mn, ТУГ.мн, Newswire.mn, Montsame.mn, Sergelt.mn зэрэг 5 телевиз, 1 радио, 1 өдөр тутмын сонин, 6 мэдээллийн сайтын сэтгүүлчид мэдээ бэлтгэж дамжуулсан. ЦССҮТ-ийн 10 гаруй төлөөлөл сайн дурын авлагагүй цусны донор үйлс, 2025 оны цусны донорын Дэлхийн өдрийн арга хэмжээний онцлогийн талаар ярилцлага өгч олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийж цусны донорын эгнээнд нэгдэх, цус, цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэхэд иргэд, байгууллага хамт олныг оролцохыг уриалсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | БСТЗ 1.1.2<br>“Цусаа бэлэглэх өдөр”-ийг 2-12 дугаар саруудад зохион байгуулна. | Цусаа бэлэглэх өдөр тэмдэглэсэн тайлан. | 2024 онд Цусаа бэлэглэх өдрийг 11 удаа зохион байгуулж цусны байнгын донор, донор хамт олныг шагнаж алдаршуулсан. | Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-ийн арга хэмжээг 10 удаа өвөрмөц, шинэлэг хэлбэрээр зохион байгуулж цусны донор, донор хамт олон, донорын үйлсийг дэмжигч байгууллагуудыг шагнаж алдаршуулсан байна. | I-IV улирал | Сар бүрийн 3-ны Цусаа бэлэглэх өдрийг тасралтгүй 10 жил зохион байгуулж энэ онд 11 удаа зохион хамгийн сүүлд 148 дахь удаагийн арга хэмжээ арга хэмжээ зохион байгуулснаараа онцлог болсон. Уг арга хэмжээг БЗД-ийн ИТХ, ЗДТГ, БГД-ийн ИТХ, ЗДТГ, МУЗН, СБД-ийн УЗДШХ, Насан туршийн боловсролын төв, HWPL ОУ-ын байгууллага, МДХ ТББ-той хамтран дээрх дүүргийн нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулж тэднээр дамжуулан дүүргийн иргэдийн цусны донорын талаарх мэдлэг хандлагыг өөрчлөх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, олон удаа цусаа өгсөн хүндтэй доноруудыг хамт олон дунд нь алдаршуулах зэрэг арга хэмжээг өвөрмөц байдлаар зохион байгуулж ажилласан. Тухайн өдрөөр цус цуглуулах арга хэмжээг зохион байгуулж БЗД-ийн ИТХ, ЗДТГ, БГД ИТХ, ЗДТГ, МУЗН, СБД УЗДШХ, Этүгэн их сургууль зэрэг 10 гаруй байгууллагын оюутан, ажилчид, харьяа байгууллагуудын ажилтан иргэдийн төлөөлөл 1100 гаруй хүн донорын эгнээнд нэгдсэн байна. Мөн энэ үеэр дараах цусны байнгын донор, донорын үйлсийг дэмжигч иргэд байгууллагуудыг шагнаж алдаршуулсан байна. Үүнд:<br>1. Алтан донор-1<br>2. Мөнгөн донор-14<br>3. Хүрэл донор-42<br>4. Бахархал 50 тэмдгээр -25<br>5. Бахархал 40 тэмдэгээр -38<br>6. Бахархал 30 тэмдгээр -55<br>7. Бахархал 20 тэмдгээр-85<br>8. Бахархал 10 тэмдгээр-254<br>Үйл ажиллагааг БЗД-ийн ИТХ, ЗДТГ , Улаан загалмайн дунд шатны хороо 1,2 сая төгрөгийн, Баянгол дүүргийн ИТХ, ЗДТГ гарын бэлэг, МУЗН 500000 төгрөгийн гарын бэлэг, МДХ ТББ гарын бэлэг, ULKER mongolia 0,8 сая төгрөгийн гарын бэлэг тус тус олгож арга хэмжээг дэмжин хамтран зохион байгуулж, цусны байнгын доноруудыг шагнаж алдаршуулсан. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Амьдрал бэлэглэе пейж хуудас Донор та баатар фейсбүүк группээр үйл ажиллагаа, донор алдаршуулалтын мэдээллийг байршуулж 84000 хүн дэмжиж, 88000 хүнд хүрсэн байна. | 100% |
| 15. | БСТЗ 1.1.3<br>Цусны донорт ферритин тодорхойлж донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлнэ. | -Ферритин тодорхойлох шинжилгээнд хамрагдсан донорын тоо<br>-Шинжилгээний дүгнэлт | | 2024 онд 1135 байнгын донорт ферритин тодорхойлох шинжилгээ хийсэн. Шинжилгээгээр Ферритины хэмжээ 0-15нг/мл хүртэл буурсан үзүүлэлттэй 205 /18%/ донорын цус өгөх | 1300-аас доошгүй донорт ферритин тодорхойлон, шинжилгээний хариуд дүгнэлт хийж, | Цусны донорын эрүүл мэндийг хянах, хамгаалах хүрээнд 1305 донорт ферритин тодорхойлох шинжилгээг хийж, хариуг олгосон байна.<br>Шинжилгээнд хамрагдсан доноруудын 940 (72%)-д нь ферритиний хэмжээ хэвийн, 34 (2.6%)-д нь ихэссэн, 331 (25.4%)-д нь багассан үзүүлэлттэй байна. Хэвийн хэмжээнээс багассан доноруудад ДЭМБ-ын зөвлөмж болон олон улсад хэрэгжүүлж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хугацааг 6-12 сараар түр хойшлуулж сөрөг хариу урвалаас сэргийлсэн. | сөрөг хариу урвалаас сэргийлсэн байна. | буй заавар зөвлөмжийг үндэслэн 6-12 сарын хугацаанд цусаа өгөх хугацааг түр хойшлуулах арга хэмжээ авч ажиллаж байна. | |
| 16. | БСТЗ 1.1.3 Хөдөлгөөнт хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагаанд зориулалтын ор ашиглаж донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлнэ. | Зориулалтын ор ашигласан хувь | 2024 онд хөдөлгөөнт хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааны 60%-д зориулалтын ор ашигласан. | Хөдөлгөөнт хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааны 65% хувьд зориулалтын ор ашиглаж, донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлсэн байна. | I-IV улирал | 2025 оны 12 сарын 25-ны байдлаар 93 удаагийн явуулд зориулалтын орыг хэрэглэж 10083 донороос цус цуглуулсан нь цус цуглуулах үйл ажиллагааны 76.9%-д нь хэрэглэсэн байна. Зөөврийн орыг явуул зохион байгуулах байгууллагад өмнөх өдөр байршуулах ажлыг ИТТ-тэй хамтран зохион байгуулсан. Зөөврийн орыг хэрэглэснээр донорт тав тухтай орчныг бүрдүүлж, донорын аюулгүй байдал, цус өгсний дараах хариу урвалаас сэргийлэх ач холбогдолтой байна. Донорт илрэх сөрөг хариу урвал өмнөх онтой харьцуулахад 4.1% буурсан үзүүлэлттэй байна. | 100% |
| 17. | БСТЗ 1.1.3 Цусны ерөнхий шинжилгээг үе шаттай нэвтрүүлж, донорын эрүүл мэндийг хамгаална. | -Цусны ерөнхий шинжилгээ хийсэн донорын тоо -Шинжилгээний үр дүн | 2024 онд 600 донорт цусны ерөнхий шинжилгээ хийснээс донорын Цусны ерөнхий шинжилгээний үр дүнгээр 522 донороос эс цуглуулсан. | Баянзүрх цус цуглуулах төвд цусаа өгөхөөр ирсэн 3000-аас цөөнгүй донорт цусны ерөнхий шинжилгээ хийж, үр дүнг үнэлсэн байна. | I-IV улирал | 2025.12.25-ны байдлаар 3120 донорт цусны ерөнхий шинжилгээг 32 үзүүлэлтээр хийж, хариуг тухайн өдрийн донорын үзлэг хийж буй эмчид цаасан хэлбэрээр олгож, үндсэн 8 үзүүлэлтийг цахим программд оруулж мэдээллийг хадгалсан.<br>Нийт хийгдсэн 3120 шинжилгээний 2733 (87.6%) нь хэвийн, 387 (12.4%) хэвийн бус байсан ба шинжилгээний хариуг үзлэгийн эмч олгож дотоод сүлжээнд санамжийг оруулсан.<br>Үүнийг үзүүлэлтээр авч үзвэл:<br>-цагаан эсийн үзүүлэлтүүд ихэссэн 159 (41%),<br>-цагаан эсийн үзүүлэт багассан 22 (5,8%),<br>-улаан эсийн үзүүлэлтүүд ихэссэн 206 (53,2%) хариу гарсан байна. | 100% |
| 18. | БСТЗ 1.2.1 Цусны доноруудын резусын дэд бүлгийг тодорхойлж, цахим мэдээллийн санг баяжуулна. | -Резусын дэд бүлгийг тодорхойлсон тоо, -Цахим программд оруулсан донорын тоо | 2024 онд 4070 донорт резусын дэд бүлгийг тодорхойлж донор инфо үндсэн үйл ажиллагааны программд мэдээллийг оруулж мэдээллийн санг үүсгэсэн. | 4500 цусны донорын резусын дэд бүлгийг тодорхойлж донор инфо үндсэн үйл ажиллагааны программд мэдээллийг оруулж мэдээллийн санг баяжуулан, шаардлагатай тохиолдолд мэдээллийг цахим сангаас хайх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | I-IV улирал | Нийт 4524 цусны донорт эмнэлзүйн ач холбогдол өндөртэй резусын дэд бүлэг болох C, c, E, e эсрэгтөрөгчийг тодорхойлж үр дүнг донор инфо үндсэн үйл ажиллагааны цахим программд 100% оруулж мэдээллийн санг баяжуулан ажиллав.<br>Шаардлагатай тохиолдолд мэдээллийг цахим сангаас хайх нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн. | 100% |
| 19. | БСТЗ 1.2.1 Донорын гемоглобины хэмжээ тодорхойлох шинжилгээнд гемоглобин | -Гемоглобин метрийн аргаар шинжилгээ хийсэн донорын тоо | 2007 оноос цусны донорын гемоглобины хэмжээг зэсийн сульфатын чанарын аргаар | Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гемоглобинметр буюу тоон аргаар цусны донорын гемоглобины хэмжээг тодорхойлсон байна. | II-IV улирал | Донорын гемоглобиныг тоон аргаар тодорхойлох буюу Hb гемоглобин тест метр төхөөрөмжийг 2025 оны 5 сард хүлээн авч дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>-2025.05.14-нд Гемоглобин тодорхойлох САЗ-НЛ-3-ДШ-08-01, АЗ-НЛ-3-ДШ-04-01-ийг боловсруулсан, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | метрийн аргыг нэвтрүүлнэ. | | тодорхойлж байна. | | | -2025.05.15-д Донор зохион байгуулалтын тасаг болон Нэгдсэн лабораторийн тасгийн нийт 19 эмч, мэргэжилтнүүдэд ажлын байрны сургалт хийсэн.<br>-Шинжилгээний аргыг шалгаж, үр дүн сайн байсан тул үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.<br>-Нийт 11000 донорт шинжилгээг хийж үр дүнг олгосон. | |
| 20. | БСТЗ 1.3.1<br>Цусны бүлгийн зөрүү болон эргэлзээтэй бүлэг тодорхойлох шинжилгээний алгоритмийг боловсруулж, батлуулна. | -Батлагдсан алгоритм | Цусны бүлгийн зөрүү болон эргэлзээтэй бүлэг тодорхойлоход стандарт ажиллагааны заавар мөрдөж байсан. | Цусны бүлгийн зөрүү болон эргэлзээтэй бүлэг тодорхойлох шинжилгээний алгоритм боловсруулж, захирлын тушаалаар батлуулан, үндэсний хэмжээнд мөрддөг болсон байна. | I-IV улирал | Цусны бүлгийн зөрүү болон эргэлзээтэй бүлэг тодорхойлох шинжилгээний алгоритмийг донорын болон үйлчлүүлэгчийн сорьцонд гэсэн 2 чиглэлээр боловсруулж, төвийн захирлын 2025.04.08-ны өдрийн А/23 тоот тушаалаар батлуулсан. Алгоритмийг цусны салбар төвийн эмч, мэргэжилтнүүдэд Цус сэлбэлт судлалын салбарын Үндэсний семинараар танилцуулж, батлагдсан тушаалыг хүлээлгэн өгсөн. | 100% |
| 21. | БСТЗ 1.2.1<br>Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэж, аудитад хамрагдана. | -Эрсдэлийн үнэлгээний тайлан, зөвлөмж<br>-Аудитын дүгнэлт, зөвлөмж | 2020 онд Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн. | Эрх бүхий байгууллагаар Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийлгэж тайлан, зөвлөмж гарсан байна. | I-II улирал | Пи Эс Эс Эй ХХК-тай 2025.01.29-ний өдөр АУГ/25-01 дугаартай ажил гүйцэтгэх гэрээгээр системийн болон дэд бүтцийн эмзэг байдлыг тодорхойлох пенетрешн нэвтрэлтийн шалгалт, эмзэг байдлын үнэлгээ хийлгэж тайлан, зөвлөмжийг 2025.11.01-ны өдөр хүлээн авсан.<br>Би тех ХХК-тай 2025.09.30-ны өдөр АУГ/25-09 дугаартай мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх ажл гүйцэтгэх гэрээ байгуулан аудит хийлгэж өгсөн дүгнэлт, зөвлөмжийг 2025.11.17-ны өдөр хүлээн авсан.<br>Аудит, эрсдэлийн үнэлгээний сайжруулах зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган засч, сайжруулах ажлын хийж ,тайланг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвд хүргүүлсэн. | 100% |
| 22. | БСТЗ 1.2.1<br>Үндсэн үйл ажиллагааны программд шаардлагатай хөгжүүлэлт хийнэ. | -Алба, тасгуудаас ирсэн ажлын даалгавар<br>-Программд хийсэн хөгжүүлэлтийн мэдээлэл | 2024 онд төвийн үндсэн үйл ажиллагааны программд сөрөг хариу урвал, тэмбүүгийн түргэвчилсэн тест, ферритин, сийвэнгийн уураг зэрэг нийт 58 засвар, хөгжүүлэлт хийсэн. | Ажлын даалгаврын дагуу үндсэн үйл ажиллагааны программд шаардлагатай хөгжүүлэлт хийж, үйл ажиллагааг сайжруулсан байна. | I-IV улирал | Нэгдсэн лабораторийн тасгаас ирсэн ажлын даалгаварын дагуу Үндсэн үйл ажиллагааны Donorinfo программын төлбөрт үйлчилгээний хэсэгт цусны ABO бүлэг баталгаажуулах хэсгийг нэмж оруулсан. Баталгаажилт хийгдсэн иргэний цусны бүлгийн мэдээлэл E-Mongolia нэгдсэн системд ордог зохицуулалт хийсэн. Мөн 2025.01.23 өдрийн лабораторийн тасгаас ирүүлсэн АУГ/25-04 дугаартай гэрээгний дагуу халдвар илрүүлэх бүрэн автомат PCR аппаратыг үндсэн үйл ажиллагааны программд холбон автоматжуулсан.<br>Мөн цусны донорын эрүүл мэндийн картыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд төвийн цахим хуудсыг шинээр хийж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23. | БСТЗ 1.2.1 Иргэдийн цусны бүлгийн мэдээллийн “E-Mongolia” нэгдсэн системээр тогтмол харуулна. | -Нийт бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн тоо<br>-Үйлчлүүлэгчийн өсөлтийн хувь | 2024 оны байдлаар “E-Mongolia” нэгдсэн системээр давхардсан тоогоор нийт 171541 цусны донор, үйлчлүүлэгчид цусны бүлгийн мэдээллээ авсан байна. | Үндсэн үйл ажиллагааны программын аюулгүй байдал, хэвийн ажиллагаа хангаж, “E-Mongolia” нэгдсэн системээр цусны донор, үйлчлүүлэгчд цусны бүлгийн мэдээллээ харах нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна. | I-IV улирал | Цус сэлбэлт судлалын салбараар үйлчлүүлсэн Цусны донор, үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн мэдээллийг E-Mongolia системээр харах боломжийг тогтмол бүрдүүлж, 2025/01/01-2025/12/10 байдлаар давхардсан тоогоор нийт 98720 донор, үйлчлүүлэгч цусны бүлгийн мэдээллээ авсан байна.<br>Мөн энэ хугацаанд E-Mongolia системээр харах боломжтой шинэ Цусны донор, үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн 30104 мэдээлэл нэмэгдсэн байна. 2024 онтой харцуулхад 61 хувь өссөн байна. | 100% |
| 24. | БСТЗ 1.2.1 “Цусны донор” аппликейшны хөгжүүлэлт хийж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | -Ажлын даалгавар -Ажлын тайлан | 2024 онд Цусны донор аппликейшныг төвийн серверт байршуулан, системийн шинэчлэл хийгдэж, явуулын цус цуглуулалтын хуваарь, шинжилгээний хариуны мэдээллийн нэмэлт функц нэмэгдсэн. | Ажлын даалгаврын дагуу загвар, функцүүдэд шаардлагатай засварыг хийж, “Цусны донор” аппликейшны байнгын ажиллагааг хангаж ажилласан байна. | I-IV улирал | 2025.01.23 өдөр АУГ/25-03 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ программ хөгжүүлэгчтэй хийгдсэн. Гэрээний ажлын даалгаварт орсон засаж сайжруулах ажил хийгдэж, 2025 оны 11 сард тест хувилбар, хөгжүүлэлтийн эрх хүлээн авч, сайжруулалт хийж байна. | 70% |
| 25. | БСТЗ 1.2.1 ЦССҮТ-ийн дотоод сүлжээнд нэвтрүүлсэн “Active directory, domain controller” нэгдсэн системийн хэвийн ажиллагааг хангана. | -Системд холбогдсон компьютерын тоо | 2024 онд төвийн дотоод сүлжээнд ашиглагддаг 30 компьютерыг “Active directory, domain controller” нэгдсэн системд холбосон. | Төв байрны дотоод сүлжээнд ашиглаж буй нийт компьютерыг “Active directory, domain controller” нэгдсэн системд бүрэн холбож, дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангасан байна. | II-IV улирал | ЦССҮТ-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн “Active directory, domain controller” нэгдсэн системд төвийн хэмжээнд ашиглагдаж байгаа сүлжээнд холбогдсон 41 компьютерыг 100% холбосон. Уг Active directory, domain controller нэгдсэн системд холбогдсоноор гадны зөөврийн хард диск, флаш гэрэг зөвшөөрөлгүй төхөөрөмжийг ашиглах боломжгүй болохоос гадна зөвшөөрөгдөөгүй программ хангамж татах, ашиглах боломжгүй болгосон. Ингэснээр гадны халдлагад өртөх, хэрэглэгчээс үүдэлтэй мэдээлэл алдагдах эрсдэлийг бууруулсан. | 100% |
| 26. | БСТЗ 1.3.1 Цуглуулсан цусны нэгж бүрд цусны бүлэг тодорхойлж, цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээ хийнэ. | -ABO, Резус, Келл бүлэг тодорхойлсон хувь,<br>-Гепатит B, C, ХДХВ тэмбүүгийн халдвар илрүүлэх | 2024 онд цуглуулсан 34256 нэгж цусанд цус сэлбэлтээр дамжих 4 халдвар болон ABO, Резус, Келл бүлгийг 100% тодорхойлж, | ДЭМБ-ын зөвлөмж, шинжилгээний зураглал (алгоритм)-ыг баримтлан, цуглуулсан цусны нэгж бүрд цус сэлбэлтээр дамжих 4 халдвар болон ABO, Резус, Келл бүлэг тодорхойлох | I-IV улирал | Цуглуулсан цусны 34261 нэгжид ДЭМБ-ын зөвлөмж, шинжилгээний зураглал (алгоритм)-ыг баримтлан, цуглуулсан цусны нэгжид цус сэлбэлтээр дамжих 4 халдвар болон ABO, Резус, Келл бүлэг тодорхойлох шинжилгээг 100% хийсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинжилгээ хийсэн хувь | баталгаажуулсан. | шинжилгээг 100% хийсэн байна. | | | |
| 27. | БСТЗ 1.4.1 Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | -Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ (өсөлтийн хувь) | 2024 онд 2719 нэгж эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэн, 277 нэгж эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлэн ялтаст эсийн өтгөрүүлэг үйлдвэрлэж ЭТИ ХШС-ийн үйлдвэрлэл 14,0 хувиар буурч, ЭТИ ЯЭӨ-ийн үйлдвэрлэл 37,9 хувиар өссөн. | ЭТИ ХШС-ийн 3500 нэгж, ЭТИ ЯЭӨ-ийн 320 нэгжийг үйлдвэрлэж эмнэлэгт олгосон байна. Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувийг нэмэгдүүлсэн байна. | I-IV улирал | 2025 онд эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн бүтээгдэхүүн нийт 3820 нэгжийг үйлдвэрлэхээс 3142 нэгж үйлдвэрлэж биелэлт 82% байна. Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэн 3500 нэгжийг үйлдвэрлэхээс 3000 үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 85%, эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 320 нэгжийг үйлдвэрлэхээс 142 нэгж үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 44% байна. 2025 оны 2 сард аппаратны гэрэл шатаж 1 сар зогссон, 7 сарын 1-29 хүртэл цахилгаан тасарсны улмаас 1 сар ажиллаагүй, 9 сард филтер эвдэрсний улмаас 10 хоног ажиллаагүй тул төлөвлөгөөний биелэлт буурсан байна. | 90% |
| 28. | БСТЗ 1.4.1 Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | -Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ (өсөлтийн хувь) | 2024 онд цагаан эсгүйжүүлсэн улаан эс 5681 нэгжийг үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 19 хувиар өссөн. | Цагаан эсгүйжүүлсэн улаан эс 7000 нэгжийг үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн хувийг нэмэгдүүлсэн байна. | I-IV улирал | 2025 онд 7000 нэгжийг үйлдвэрлэхээс 7433 нэгж Цагаан эсгүйжүүлсэн улаан эс үйлдвэрлэсэн ба төлөвлөгөөний биелэлт 106% байна. Өмнөх оны мөн үеэс 31%-р өссөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29. | БСТЗ 1.4.1 Технологи шингэсэн бүтээгдэхүүний чанарын шинжилгээний лавлах хэмжээг (норм) тогтооно. | Тогтоосон лавлах хэмжээ | - | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэн, нэгтгэж савласан криопреципитатыг чанарын шинжилгээнд хамруулж бүлэгнэлтийн үзүүлэлтийн лавлах хэмжээг тогтоосон байна. Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг, Туяагаар шарсан ялтаст эсийн өтгөрүүлэг, нэгтгэж савласан ялтаст эсийн өтгөрүүлгийг чанарын шинжилгээнд хамруулж эсийн лавлах хэмжээг тогтоосон байна. | I-IV улирал | -Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн хөлдөөхийн өмнөх болон дараа 104 нэгжийг чанарын шинжилгээнд хамруулж VIII факторын лавлах хэмжээг FVIII-70 IU/нэгж байхаар тогтоосон.<br>“Хөлдөөсөн шинэ сийвэн дэх эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэхийн өмнө ба дараах VIII факторын агууламжийн харьцуулсан судалгаа” сэдвээр эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн.<br>Үргэжлүүлэн шинжилгээнд хамруулан хэмжээг тогтоох:<br>-Нэгтгэсэн криопреципитатын 45 нэгжийг лавлах хэмжээг тогтоох шинжилгээнд хамруулж фибриноген-140 мг/нэгж, FVIII-70 IU/нэгж байхаар тогтоосон.<br>-Нэгтгэж савласан, туяагаар шарсан, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн бүтээгдэхүүний 35 нэгж дээжийг лавлах хэмжээ тогтоох шинжилгээнд хамруулж, эсийн лавлах хэмжээг тромбоцит-200*$10^9$/нэгж байхаар тогтоосон. | 100% |
| 30. | БСТЗ 1.4.2 Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүхэл цус боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ (Reveos® Automated Blood Processing System)-ыг нэвтрүүлнэ. | -Нэвтрүүлсэн шинэ технологи,<br>-Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ,<br>-Сургалтад хамрагдсан ажилтны тоо | Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гар ажиллагаатай, хаалттай систем ашиглаж байсан. | “Бүхэл цус боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ”-ыг цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Ажилтнуудыг сургалтад хамруулсан байна. | I-IV улирал | Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүхэл цус боловсруулах үйлдвэрлэлийн процессыг бүрэн автоматжуулсан платформ нэвтрүүлэхээр төвийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган ЦССҮТ/2025202010 тендер шалгаруулалтын дугаартай “Эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат” тендерт 682,500,000 төгрөгийн үнэ бүхий Багц №2: “Бүхэл цус боловсруулах автомат аппарат /цус, цусан бүтээгдэхүүний бүрэн автомат технологи/ тендерийг 2025 оны 02 сарын 26-ны өдөр зарлаж, 2025 оны 04 сарын 09-ний өдөр нээсэн. Космос тек монгол ХХК нь гүйцэтгэгчээр шалгарсан ба 2025 оны 04 сарын 17-ний өдөр шалгарсан оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэж, үр дүнг цахим системд нийтэлсэн. 2025 оны 04 сарын 28-ний өдөр “Космос тек монгол” ХХК-аас Багц №2 буюу Цус, цусан бүтээгдэхүүний бүрэн автомат технологийн үйлдвэрлэгч нь 2025 онд манай улсад нийлүүлэх боломжгүй байгаа тул дээрх тоног төхөөрөмжийг нийлүүлэх боломжгүй болсон тухай 81 тоот албан бичгээр мэдэгдсэн. | 70% |
| 31. | БСТЗ 1.4.2 Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн | Шинэчилсэн тоног төхөөрөмжийн мэдээлэл, -Цуглуулсан | 2016 онд ЭМСХХ-5 төслөөр технологийн шинэчлэл | PCS, MCS аппарат, ELISA аппарат, сервер компьютер, галт хана зэрэг сүүлийн үеийн технологийн эмнэлгийн | I-IV улирал | Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хамтын ажиллагааны хүрээнд хандиваар нийлүүлэгдсэн Dell Optiplex Tower 7010 маркийн 10 ширхэг суурин компьютер, Dell Inspiron 3520 маркийн 10 ширхэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэлийг үе шаттай хийнэ. | цус, цусны бүрэлдэхүүн хэсгийн тоо<br>-Үйлдвэрлэсэн цус цусан бүтээгдэхүүний тоо, хувь | хийсэн. 2014 онд ЦЦБ-ий үйлдвэрлэл 65.5 мян нэгж байсан бол 2024 онд 127.6 мян нэгж болж 1.9 дахин нэмэгдсэн. ЦЦБ-ий нэр төрөл 14 байсныг 36 болж нэмэгдүүлсэн. | болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулалт, ЦЦБ-ий үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажилласан байна. | | зөөврийн компьютер, huawei брэндийн таблет 10 ширхэг техник тоног төхөөрөмжөөр шинэчилсэн.<br>2025 оны 02 сарын 26-ны эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат нийлүүлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулж тендер зарлаж. Багц №1 Эс болон сийвэн цуглуулах аппаратны нийлүүлэгчээр "Космос тек монгол" ХХК, Багц №3 буюу элиза уншигч угаагч аппаратны нийлүүлэгчээр "Мед импекс интернэйшл " ХХК шалгарч гэрээ байгуулаж гэрээний дагуу ханган нийлүүлэгч байгууллага тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж үе шаттай шинэчлэлийг хийсэн. | |
| 32. | БСТЗ 1.4.2<br>Цус бүлэгнэлтийн эмгэг, гемофили өвчний генийн эмчилгээний хамтарсан төсөл хэрэгжүүлнэ. | -Төслийн явцын тайлан | АШУҮИС, Японы Жичигийн Их Сургуультай хамтарсан төслийн багийн уулзалт 5 удаа хийгдсэн. Судалгааны сэдэв аргачлалыг АУ-ны ёс зүйн хороогоор хэлэлцүүлсэн. | Төслийн тайлант оны төлөвлөгдсөн ажлууд бүрэн хийгдэж, явцын тайлан гарсан байна. | I-IV улирал | Монгол–Японы эмнэлгийн харьяа гемофилийн оноштой нийт 78 үйлчлүүлэгчийг хамруулсан судалгаа бүрэн дуусаж, судалгааг олон улсын сэтгүүлд хэвлүүлэхээр бэлдэж байна. Ингэснээр төслийн эхний шат дуусах шатандаа шилжээд байна.<br>Мөн Японы Жичи их сургууль руу саармагжуулах эсрэгбиеийн шинжилгээний үр дүнг хүргүүлж, судалгааны дараагийн шатны бэлтгэл хангаж ажиллаж байна. | 100% |
| 33. | БСТЗ 1.4.2<br>Эмнэлгүүдийн цус цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисэгчгүй нисэх төхөөрөмж ашиглах технологийг нутагшуулна. | -Нисэгчгүй нисэх төхөөрөмжөөр ЦЦБ тээвэрлэсэн нислэгийн тоо<br>-Эрүүл мэндийн байгууллагын тоо | Яаралтай үед эмнэлгүүдийн цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисэгчгүй нисэх төхөөрөмжийг нэвтрүүлэх зорилгоор 3 эмнэлэгт 5 төрлийн 140 нэгж цус, цусан бүтээгдэхүүн (38,259 мл)-ийг 50 удаагийн нислэгээр хүргэсэн. | AirTruck тусгай ложистикийн нисэгчгүй нисэх төхөөрөмжийн хөгжүүлэлтийг хийж, 30 эрүүл мэндийн байгууллага руу ЦЦБ-ий тээвэрлэлтийг хийсэн байна. | I-IV улирал | 2025 оны 5 сарын 09 өдрөөс PF-4 дроноор цус цусан бүтээгдэхүүний тээвэрлэлт эхэлсэн. ЭХЭМҮТ-төрөх, ЭХЭМҮТ-хүүхэд, Монгол-Японы эмнэлэг, ХӨСҮТ, СБД-ийн Нэгдсэн эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Брилант, ГССҮТ, БГД эмнэлэг, 3-р эмнэлэг, Мөнгөнгүүр, Ач, СХНЭ,СХЭМ 14 эмнэлэгүүдрүү маршутын дагуу ЦЦБ тээвэрлэж байна. 2025 оны 5 сараас 12 сарын хугацаанд 107 өдөр 422 нислэг 3 төрлийн 388 миллилитр бүтээгдэхүүн тээвэрлэж 6540 минутын нислэг үйлдэж, замын хөдөлгөөнд оролцож цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэсэн. Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн хүргэлтээр хүлээн авсан бүтээгдэхүүнийг 639 өвчтөнд сэлбэснээс 434 яаралтай, 205 энгийн тээвэрлэлт байсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34. | БСТЗ 1.5.1 Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн 2025 оны төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана. | -Тодотгол хийж баталсан төлөвлөгөө -Тайлан | 2024 онд Төвийн гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгол хийж, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсээр батлуулсан. | Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн 2025 оны төлөвлөгөөнд тодотгол хийж батлуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж бэлэн байдлыг хангаж ажилласан байна. | I-IV улирал | Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний холбоо зарлан мэдээлэх хүснэгтийг тодотголоор оруулсан. УАБЗ-ийн нарийн бичгийн даргын 2011 оны 08 дугаар захирамжаар батлагдсан жагсаалтын дагуу ажиллагсдын үүргэвчийг шалгах үеэр ажиллагсдад танилцуулсан. Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх баг нь 2025 онд нийт 10 ажил төлөвлөн ба биелэлт 91%-ийн гүйцэтгэлтэй байна. -2025.03.24 Онцгой байдлын ерөнхий газартай хамтран галын аюулгүй байдлын танхим болон дадлагаар сургалт хийсэн. | 100% |
| 35. | БСТЗ 1.5.1 Цус, цусан бүтээгдэхүүний Улсын нөөцийн хадгалалтын аюулгүй байдлыг хангаж, нөхөн сэлгэлтийг хийнэ. | -Нууцын гэрээ -Нөхөн сэлгэлт хийсэн удаа | 2024 онд Улсын нөөцийн хөлдөөсөн шинэ сийвэнгийн нөхөн хангалтыг 3, 4, 10, 11 сард хийж, Улсын нөөцийн цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж ажилласан. | Гэрээний үүргийг хэрэгжүүлж, сийвэнгийн бүтээгдэхүүний нөхөн сэлгэлтийг бүрэн хийсэн байна. | I-IV улирал | ОБЕГ-тай байгуулсан нууцын гэрээгээр тус төв нь гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ЦЦБ-ий нөөцийг бүрдүүлэн ажилладаг. Энэ хүрээнд 2025 онд цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн чанар, аюулгүй байдлыг хангаН нөхөн сэлгэлтийг 3, 5, 10, сард хийсэн. Нөөц бүтээгдэхүүний хүчинтэй хугацааг 2029 онд дуусахаар сэлгэлт хийсэн. | 100% |
| 36. | БСТЗ 2.1.1 Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийн мэдээллийн санг баяжуулж, дүн шинжилгээ хийнэ. | -Бүртгэл мэдээллийн санд шинээр бүртгэгдсэн ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийн тоо -Дүн шинжилгээний тайлан | Бүтээгдэхүүн захиалга болон олголтын bp.mohs.mn программд ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэл илэрсэн үед мэдээлэх 3 маягтыг шинээр оруулсан. ЭМБ-аас 10 урвал хүндрэл мэдээлэгдэж, дүн шинжилгээ хийсэн. | Эрүүл мэндийн байгууллагуудын цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн мэдээллийн санг цаасан болон bp.mohs.mn программд цахим хэлбэрээр үүсгэсэн байна. Шинээр бүртгэгдсэн урвал хүндрэлд дүн шинжилгээ хийсэн байна. | I-IV улирал | Эрүүл мэндийн байгууллагуудын цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн бүртгэл мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр үүсгэн цахим мэдээний санг урвал хүндрэл илэрсэн өвчтөн болон сэлбэсэн бүтээгдэхүүний мэдээллийг агуулсан байдлаар Excel хэлбэрээр үүсгэн, хадгалж байна. 2025 оны байдлаар цус сэлбэлттэй холбоотой 8 урвал, хүндрэл бүртгэгдэж мэдээний санд хадгалагдсан. Бүртгэгдсэн урвал хүндрэлд мөшгөн тогтоолт хийж, дүн шинжилгээ хийхэд цус цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоогүй болох нь тогтоогдсон. Бүтээгдэхүүн захиалга болон олголтын bp.mohs.mn программд ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэл илэрсэн үед мэдээлэх 3 маягтыг шинээр оруулан туршилтын шатанд явагдаж байгаа ба ЭМС-ын 2019 оны А/611 дугаар тушаалын шинэчлэл, ЭМБ-уудын цахим программын нэгтгэх үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлээгүй байгаа болно. | 90% |
| 37. | БСТЗ 2.1.1 Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх | -Шинэчлэн боловсруулсан журмын төсөл -Хүргүүлсэн албан бичиг | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/17 дугаар тушаалаар ажлын хэсэг | Тушаалын төслийг боловсруулж ЭМЯ-нд хүргүүлсэн байна. | I-II улирал | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/506 дугаар тушаалаар батлагдсан “Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх” журмыг шинэчлэх ажлын хэсэг Төвийн захирлын 2025 оны А/17 тушаалын хоёрдугаар хавсралтаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Тушаалын төслийн шинэчлэлд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журмыг шинэчлэн боловсруулна. | | байгуулсан. Тушаалын төслийг боловсруулж байна. | | | ● Цусны донорын сонор сэрэмжийн онолын хэсэг, ангилал, авах арга хэмжээ, сэргийлэх үйл ажиллагаа, хөтлөх маягт бүртгэл<br>● ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой сөрөг урвал, хүндрэлийг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх сэргийлэх үйл ажиллагаа, хөтлөх маягт бүртгэл,<br>● ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой үүсэх урвал хүндрэлийн ангилал, шалтгаан авах арга хэмжээ<br>зэргийг хамруулж байгаа бөгөөд ажлын хэсгийн 2 удаагийн хурлаар журмын төслийг хэлэлцэж, ЭМЯ-ны мэргэжилтэнтэй уулзалт хийж танилцуулсан. Тус журмын төслийн танилцуулга болон төслийг ЭМЯ-нд Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын мэргэжилтэнд Тушаалын төслийн танилцуулгын хамт 2025 оны 05 сарын 29-нд telegram хаягаар хүргүүлсэн. | |
| 38. | БСТЗ 2.2.1 Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуногематологийн лавлагаа шинжилгээг хийнэ. | -Лавлагаа шинжилгээний нэр, төрөл, тоо, үр дүн | Хувийн тохироо тодорхойлох, эргэлзээтэй бүлэг тодорхойлох, Кумбсын шууд ба шууд бус урвал, эсрэг бие илрүүлэх, дүйн тодорхойлох, резус сөрөг баталгаажуулах, анти-Д титр тодорхойлох, резусийн дэд бүлэг тодорхойлох 7 нэр төрлийн шинжилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хийсэн. | Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуногематологийн лавлагаа шинжилгээг 100% хийж, үр дүнг тооцож, хариуг олгосон байна. | I-IV улирал | Үйлчлүүлэгчийн хүсэлтээр<br>Хувийн тохироо тодорхойлох-425,<br>Эргэлзээтэй бүлэг тодорхойлох-22,<br>Кумбсын шууд ба шууд бус урвал-522,<br>Эсрэг бие илрүүлэх, дүйн тодорхойлох-238,<br>Резус сөрөг баталгаажуулах-110,<br>Анти-Д титр тодорхойлох-687,<br>Резусийн дэд бүлэг тодорхойлох-242,<br>элэг шилжүүлэн суулгах үеийн тохироо-2100 тус тус хийж шинжилгээний үр дүнг олгон ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39. | БСТЗ 2.3.1 Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэн ажиллаж, магадлах аудитад хамрагдана. | Магадлах болон баталгаажуулах аудитын гэрчилгээ | 2023 онд Нэгдсэн менежментийн тогтолцооны аудит ISO 9001:2015, ISO 45001:2018 магадлах аудитад хамрагдсан. | Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж, ISO 9001:2015 магадлах болон ISO 45001:2018 баталгаажуулах аудитад тус тус амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан байна. | IV улирал | Тус төв нь 2016 оноос эхлэн Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 болон Хөдөлмөрийн Эрүүл мэнд аюулгүй байдлын ISO 45001:2018 менежментийн тогтолцооны стандартыг тогтовортой хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулж жил бүр магадлах болон баталгаажуулах аудитад тогмол хамрагдан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Монсертф ХХК-ий баталгаажуулалтын аудитад Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын магадлах, Хөдөлмөрийн Эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын давтан баталгаажуулах аудитад тус тус амжилттай хамрагдаж, гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмших шаардлага бүрэн хангасныг тодорхойлуулсан. | 100% |
| 40. | БСТЗ 2.3.1 Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2024 шинэчилсэн хувилбараар итгэмжлүүлэх бэлтгэл ажлыг хангана. | -Итгэмжлэлд хамрагдах албан бичиг -Бэлтгэл хангасан ажлын тайлан | 2024 онд Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартыг тогтвортой хэрэгжүүлж ирсэн. | Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2024 шинэчилсэн хувилбараар итгэмжлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, албан бичгээр хүсэлт хүргүүлсэн байна. | I-IV улирал | Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2024 шинэчилсэн хувилбарын дагуу өөрчлөлтийг хийж, итгэмжлүүлэх хүсэлтийг илгээхэд шаардлагатай 18 төрлийн мэдээлэлд хамаарах баримт бичиг, түүний нотолгоог бэлтгэн цахим хэлбэрээр давтан итгэмжлэлд хамрагдах хүсэлтийг Үндэсний итгэмжлэлийн төвд 2025.04.14-ний өдөр илгээсэн. Итгэмжлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 3 эмчийг шинэчилсэн стандартын сургалтанд хамруулсан. Баримт бичгийн шинэчлэл хийсэн. Үүнд: ЧГА, 13 журам, чанарын үзүүлэлтийг шинэчлэн сайжруулсан. 3 журмыг байгууллагын журамтай нэгтгэж, 4 журмыг лабораторийн бусад журамтай нэгтгэж өөрчилсөн. Хүсэлтийн дагуу 5 сарын 20-21 хооронд Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын А/124 тоот тушаалаар ҮИТ-ийн БХЗГ-ын мэргэжилтэн Л.Баянжаргалаар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж газар дээрх үнэлгээг хийсэн. Үнэлгээгээр үл тохирол гараагүй.<br>2025 оны 6 сард техникийн хорооны хурлаар үнэлгээний дүнг хэлэлцүүлж, 4 жилийн хугацаагаар итгэмжлүүлэх саналыг үнэлгээний багаас дэвшүүлж, техникийн хорооны гишүүд 100%-ийн саналаар дэмжив. 2025.07.21-ний А/172 тоот тушаалаар 4 жилийн хугацаагаар итгэмжлүүлэв. | 100% |
| 41. | БСТЗ 2.3.1 Америкийн цусны банкнуудын холбооны чанарын стандарт нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. | -Бэлтгэл ажил хангах төлөвлөгөө -Шалгуур үзүүлэлтийн тайлан -Итгэмжлүүлэх хүсэлт | - | Америкийн цусны банкнуудын холбоо (AABB-Association for the advancement of blood and biotherapies)-ны чанарын стандартын шалгуур үзүүлэлтийг хангаж, үнэлгээнд хамрагдах албан хүсэлтийг илгээсэн байна. | I-IV улирал | Төвийн захирлын 2025 оны 03 сарын 07-ны А/15 тушаалаар Америкийн цусны банкнуудын холбоо (AABB-Association for the advancement of blood and biotherapies)-ны чанарын стандарт нэвтрүүлэнх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, Стандарт хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2025 оны 05 сарын байдлаар ААТМ-ын 3 удаагийн уулзалт, сургалт, зөвлөгөөнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон бусад холбогдох мэргэжилтнүүд хамрагдаж, стандартын 10 бүлэгт нөхцөл байдлын үнэлгээ хийж, эхний 4 бүлэгт хамаарах тайланг бичин, холбогдох нотлох баримт бичгүүдийг бэлтгэн орчуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ААВВ-д чанарын хяналтанд хамрагдах хүсэлтээ илгээж эхний уулзалт 12 дугаар сарын 2 дахь долоо хоногт хийхээр тохиролцсон. | |
| 42. | БСТЗ 2.3.1<br>Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлд хамрагдах бэлтгэл ажлыг хангана. | -Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн өөрийн үнэлгээний тайлан<br>-Албан бичгээр илгээсэн хүсэлт | 2023 оны 01 сард магадлан итгэмжлэлд хамрагдаж 3 жилийн хугацаатай сунгуулсан. | Давтан магадлан итгэмжлэлд хамрагдах Шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үнэлгээний тайланг гаргаж хүргүүлсэн байна. Магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн байна. | I-IV улирал | Тус төв нь 2025 оны 02 сарын 28-нд магадлан итгэмжлэлд хамрагдах бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг 100% зохион байгуулан, давтан магадлан итгэмжлэлд хамрагдах шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үнэлгээний тайланг гарган, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн https://backend.acc.hdc.gov.mn/login цахим сайтад холбогдох 36 тайланг оруулж, магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлтийг хүргүүлсэн. | 100% |
| 43. | БСТЗ 2.3.1<br>Гематологийн шинжилгээний зарим үзүүлэлтийн хэмжлийн эргэлзээг тооцно. | Хэмжлийн эргэлзээ тооцсон үзүүлэлт, үр дүн | - | Гематологийн шинжилгээний лейкоцит, гемоглобин, эритроцитийн үр дүнгийн хэмжлийн эргэлзээг тооцсон байна. | I-IV улирал | Гематологийн шинжилгээний WBC, RBC, HGB, HCT, PLT, HCT, MCV, MCH зэрэг үзүүлэлтийг сонгон хэмжлийн эргэлзээг дараах үе шатаар тооцов. Үүнд:<br>1. Донорын сорьцонд 1 сорьцыг 10 удаа давтан шинжилж, сорьцон дахь хэмжлийн эргэлзээг тооцсон.<br>2. Тохиуулгын уусмалыг 10 удаа давтан шинжилж хэмжлийн эргэлзээг тооцсон.<br>3. Хяналтын уусмалыг 10 удаа давтан шинжилж хэмжлийн эргэлзээг тооцсон.<br>4. Дээрх 3 эргэлзээнээс нэгдсэн стандарт эргэлзээг тооцож, үнэхээсээ өргөтгөсөн эргэлзээг 95%-ийн итгэлцлэлээр тус тус тооцсон.<br>**Үр дүн:**<br>WBC-3.242±0.303<br>RBC-4.771±0.129x$10^{12}$<br>HGB-14.32±3.365<br>HCT- 43.34±1.254<br>PLT- 165.7±14.99<br>MCV-90.84±0.505<br>MCH-30.01±0.542<br>Хэмжлийн эргэлзээ нь хэмжигдэхүүнд хамаарах хэмжилтийн утгын тархалт бөгөөд хэмжлийн үр дүнгийн найдвартай байдлыг илэрхийлэхэд зайлшгүй шаардлагатай юм. Жнь: RBC-4.771±0.129x$10^{12}$<br>4,642-4,9 x$10^{12}$ хооронд 95% итгэлцлийн түвшинд байна гэсэн утга юм. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44. | БСТЗ 2.3.1 “Чанарын Дэлхийн 7 хоног-Үндэсний чанарын өдөр”ийн хүрээнд аян зохион байгуулна. | -Удирдамж, төлөвлөгөө, тайлан | Донор үйлчлүүлэгч болон ЦЦБ хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагууд болон төвийн ажиллагсдад чиглэсэн “Үйлчлүүлэгчээ сонсоцгооё” өдөрлөгийг 2024 оны 11 сарын 15, 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. | “Чанарын Дэлхийн 7 хоног-Үндэсний чанарын өдөр”-ийг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тайлан гаргасан байна. | IV улирал | “Чанарын Дэлхийн 7 хоног-Үндэсний чанарын өдөр”-ийг угтан 2025 оны 11 дүгээр сарын 3-аас 12 сарын 25-ны өдрүүдийн хооронд **“Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье”** уриан дор 2 сарын аян зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2025 оны 12 сарын 25-ны байдлаар 6 үйл ажиллагааг зохион байгуулж биелэлт 100%-тай байна. | 100% |
| 45. | БСТЗ 2.3.1 “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр”-ийн хүрээнд аян зохион байгуулна. | -Удирдамж, аян, тайлан | 2024 оны 9 дүгээр сарын 17-ны дэлхийн өдрийн хүрээнд 1 сарын аян зохион байгуулсан. | Батлагдсан уриан дор “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж, үйлчлүүлэгчдэд зориулсан нэг сарын аян зохион байгуулсан байна. | III-р улирал | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдрийг "Нярай болон хүүхэд бүрд аюулгүй тусламж, үйлчилгээ" сэдвээр улсын хэмжээнд тэмдэглэх хүрээнд тус төв нь “Хүүхэд болон нярайн өвчний үеийн аюулгүй цус сэлбэлтийг сайжруулах нь” 14 хоногийн аян зарлан дараа чиглэлийн хүрээнд удирдамж гарган ажилласан. Үүнд:<br>1. Хүүхэд болон нярайн өвчний үеийн аюулгүй цус сэлбэлтийг сайжруулах нь” дэмжлэгт үнэлгээг Өргөө болон Хүрээ амаржих газруудад хийж, мэргэжил аргазүйгээр ханган ажилласан.<br>2. Нярай болон хүүхдийн өвчлөлийн үеийн цус сэлбэлтийн лабораторийн шинжилгээний онцлог, аюулгүй ажиллагаа, эрсдэлээс урьдчилан сэргийлэх сэдвээр 2025.09.19-нд нийт лабораторийн 67 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. | 100% |
| 46. | ЗГМХ 2.3.4.3 ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийг хангана. | -Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2024-2026)-ийг шинэчлэн батлуулсан. | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2024-2026)-ийн 2025 оны хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | I-IV улирал | Төвийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2024-2026)-ийг дагуу 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>- Сул ажлын байрыг нийтэд ил тод мэдээлж, сул ажлын байранд сонгон шалгаруулалт явуулах зарыг Зангиа.мн сайт, ЭМХТ-ийн HRDS систем, төвийн вэб сайт, пэйж хуудсанд тухай бүр ил тод байршуулж ажилласан. 2025 онд 3 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөн, сул байсан 2 ажлын байр буюу нийт 3 ажлын байранд Шинэ ажилтан сонгон шалгаруулах журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлан нөхөн хангалт хийсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Албан хаагчдад сар бүр олгох хоол унааны зардлыг 2025 оны 04 дүгээр сараас эхлэн Хоол 12000 төгрөг, унаа 3000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлсэн.<br><br>- 2025 оны эхний хагас жилд ЭМЯ, ЭМХТ, МЭМАҮЭХ, СБД-н Нийгмийн даатгалын хэлтэс болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинар, зөвлөгөөнд мэргэжлийн дагуу давхардсан тоогоор нийт ажиллагсдын 38 хувь хамрагдсан.<br><br>- МУ-ын ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу ур чадварын нэмэгдлийг 25 хүртэлх хувиар 5 удаа, 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг улирал бүр 60 хүртэлх хувиар урамшуулалт цалин олгосон.<br><br>- Давхардсан тоогоор 21 ажилтанд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цалинтай, цалингүй чөлөөг олгосон байна. | |
| 47. | БСТЗ 3.2.1<br>Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг, Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | -Санамж бичигт туссан арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT) 2024 оны гишүүнчлэлээ сунгасан. 2024 онд Азийн цус сэлбэлтийн холбоо (ААТМ)-той хамтын ажиллагааны гэрээг 5 жилээр шинэчлэн байгуулсан. | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг, Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, санамж бичигт туссан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | Азийн Цус Сэлбэлтийн Нийгэмлэгтэй байгуулсан 5 жилийн хамтын ажиллагааны санамж бичгийг 2024 онд үзэглэсэн бөгөөд санамж бичигт тусгагдсан зургаан чиглэлийн хүрээнд үйл ажиллагааг 100 хувь тогтмол, тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>1. Олон улсын шилдэг туршлага нэвтрүүлэх, мэдээлэл солилцооны хүрээнд цахим уулзалтыг 4 удаа хийсэн.<br>2. Олон улсын хурал, семинар, сургалт зохион байгуулах:<br>-“Эрдэм шинжилгээний XXII бага хурал”-д удиртгал илтгэлийг ААТМ-аас тависан.<br>-3 удаагийн онлайн сургалтанд эмч мэргэжилтнүүд хамрагдсан.<br>3.Лавлагаа лабораторийн хөгжүүлэлт<br>-Гель картын аргаар цусны бүлэг тодорхойлох сургалтыг орон нутгийн болон нийслэлийн лабораторийн эмч, лаборант нийт 80 хүнийг хамруулан зохион байгуулсан.<br>4. Цусны сонор сэрэмжийн тогтолцоог хөгжүүлэх хүрээнд Donor hemovigilance, Patient hemovigilance сургалтуудыг ААТМ-тай хамтран зүгмээр зохион байгуулсан.<br>5. Хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх чиглэлээр Global Journal of Transfusion Medicine сэтгүүлийн Editorial Committee-той уулзалт хийж заавлагаа авч, хамтран ажиллахаар тохиролцсон.<br>6. AABB чанарын гэрчилгээжүүлэх хөтөлбөрт хамрагдах бэлтгэл ажил хангагдсан.<br>Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT)-ийн Олон улсын хуралд 2 мэргэжилтэн оролцсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48. | БСТЗ 3.2.2<br>Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XXII бага хурлыг зохион байгуулна. | -Хэвлэгдсэн илтгэлийн хураангуй | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XXI хурлыг “Тусламж үйлчилгээ, цусны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдвийн дор зохион байгуулсан. Илтгэлийн хураангуйг хэвлэж тараасан. | Цусны албаны эрдэм шинжилгээний олон улсын онол, практикийн XXII хурлыг зохион байгуулж, илтгэлийн хураангуйг хэвлүүлсэн байна. | III улирал | Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс зохион байгуулдаг “Эрдэм шинжилгээний XXII бага хурал” -ыг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдаж нийт 42 хүн танхимаар, 6 хүн цусны салбар төвөөс цахим хэлбэрээр оролцсон.<br>ЭШБХ-аар шалгарсан илтгэлүүд:. Үүнд: 1-р байрт “Хөлдөөсөн шинэ сийвэн дэх эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэхийн өмнө ба дараах VIII факторын агууламжийн харьцуулсан судалгаа” сэдвээр Цус сэлбэлт судлалын үндэсний төвь Үйлдвэрлэлийн тасаг 2-р байрт “Булган аймгийн хүн амын цусны ABO болон Rh бүлгийн тархалтын судалгаа” сэдвээр Булган аймгийн Цусны салбар төв 3-р байрт “Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэгт 2025 онд цус цусан бүтээгдэхүүн сэлбүүлсэн үйлчлүүлэгч болон сэлбэсэн бүтээгдэхүүнд резус бүлгийн эсрэгтөрөгч тодорхойлсон дүн” сэдвээр Дундговь аймгийн Цусны салбар төв, Тусгай байрыг “Дорноговь аймгийн цус, цусан бүтээгдэхүүний хаягдлын судалгаа (2019–2024)” сэдвээр Дорноговь аймгийн Цусны салбар төв тус тус хүртлээ.<br>Итгэлийн хураангуйг цахим хэлбэрээр гаргаж нийт оролцогчдод илгээсэн. | 100% |
| 49. | ЗГМХ 2.3.2.6<br>Цус сэлбэлт судлалын салбарын “Үндэсний зөвлөгөөн”-ийг зохион байгуулна. | Үндэсний зөвлөгөөний удирдамж, тайлан, зөвлөмж | “Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт үндэсний зөвлөгөөний зохион байгуулж 21 аймгийн 26 ЦСТ-ийн нийт 77 эмч мэргэжилтэнг хамруулсан. | “Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт Үндэсний семинарыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. Үндэсний зөвлөгөөний зөвлөмж хүргүүлсэн байна. | I улирал | Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс жил бүр Цусны албаны эмч, мэргэжилтнүүдийн дунд Үндэсний семинарыг зохион байгуулдаг уламжлалын дагуу төвийн захиралын 2025 лны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/14 дугаар тушаалын дагуу Үндэсний семинарыг 03 сарын 13 - 14 өдрүүдэд цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. ЦССҮТ-ийн эмч мэргэжилтнүүд болон 26 цусны салбар төвийн эмч, мэргэжилтнүүд нийт 61 хүн танхимаар оролцсон бол цахим хэлбэрээр нийт 12 цусны салбар төвөөс 34 эмч, мэргэжилтэн үндэсний семинарт оролцлоо. Семинарт цусны салбар төвүүд өнгөрсөн оны үйл ажиллагаа, ололт амжилт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулж, төвийн эмч, мэргэжилтнүүд чиглэл чиглэлийн дагуу шинэлэг мэдээлэл, аргазүйн зөвлөмж өгч ажиллав.<br>2 кредит багц цагыг сургалтад хамрагдсан 95 хүнд олгосон<br>НЭГДҮГЭЭР байранд: ДОРНОГОВЬ аймгийн цусны салбар төв<br>ХОЁРДУГААР байранд: СҮХБААТАР аймгийн цусны салбар төв<br>ГУРАВДУГААР байранд: ХӨВСГӨЛ аймгийн цусны салбар төв<br>ТУСГАЙ байрын шагналыг ӨВӨРХАНГАЙ, ДУНДГОВЬ аймгийн цусны салбар төвүүд тодорсон.<br>Нэгдсэн зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны 103 тоот албан тоотоор аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, Хархорин, Тосонцэнгэл, Мандал, Замын-Үүд сумын нэгдсэн эснэлэгийн дарга, захирал нарт хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50. | БСТЗ 3.3.1<br>Богино хугацааны багц цагийн сургалт зохион байгуулна. | -Зохион байгуулсан сургалтын тоо,<br>-Хамрагдсан эмч мэргэжилтний тоо, тайлан | 2024 онд багц ца гийн богино хугацааны сургал тыг үндсэн 2 сэдвээр 2 удаа зохион байгуулж нийт 257 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | Богино хугацааны багц цагийн сургалтыг улирал тутамд зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангаж, чадавхжуулсан байна. | I-IV улирал | Төв нь дараах “ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ”, ”ЦУСНЫ БҮЛЭГ, ХУВИЙН ТОХИРОО ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ” 2 сэдвээр багц цагийн хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн салбар зөвлөл, ЭМХТ өөр батлуулан хэрэгжүүлдэг. 2025 онд нийт 5 удаагийн багц цагийн сургалтыг зохион байгуулж нийт 232+ эмч эмнэлэгийн мэргэжилтнүүд хамрагдсан байна.<br>● Цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох аргачлал багц цагийн сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 58 эмч эмнэлэгийн мэргэжилтнүүд хамрагдсан.<br>● Цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох аргачлал - гель картын аргыг нэвтрүүлэх багц цагийн сургалтыг орон нутгийн эмнэлэгийн мэргэжилтнүүдийг идэвхижүүлэх зоритлгоор 70 мэргэжилтэнг хамруулан зохион байгуулсан.<br>● Цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээ багц цагийн сургалтыг 2025 оны 12 сарын 16-ны өдөр танхимаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Сургалт зохион байгуулах тухай зар, бүртгэлийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн сан программд үүсгэсэн болно.<br>● 2025 оны Цусны салбарын үндэсний зөвлөгөөн, Цусны салбарын сувилагчдын II зөвлөгөөнийг тус тус 2 багц цагтайгаар зохион байгуулж нийт 104 мэргэжилтэн хамрагдсан. | 100% |
| 51. | БСТЗ 3.3.1<br>Нийт ажилчдын авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэтгэл судлал, ёс зүйн болон бусад тасралтгүй сургалтыг зохион байгуулна. | -Батлагдсан сургалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь<br>-Оролцогчдын тоо, бүртгэл, тайлан | Нийт ажилчдын тасралтгүй сургалтыг 2024 оны байдлаар байдлаар 10 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 483 ажилтан хамрагдсан. | Нийт ажилчдын тасралтгүй сургалтыг 10-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. | I-IV улирал | 2025 онд сургалтын төлөвлөгөөгөөр 13 сургалт төлөвлөснөөс 18 сургалт зохион байгуулагдаж хэрэгжилтийн хувь 100% тус сургалтуудад давхардсан тоогоор 660 ажилтан хамрагдсан.<br>2025.01.29 болон 2025.04.02 “ААВВ чанарын гэрчилгээний сургалт” - 13 хүн;<br>2025.01.30“Ажлын байрны стресс менежмент” 56 хүн<br>2025.02.06 “Чанарын шалгуур үзүүлэлт боловсруулахад анхаарах зүйлс” - 56 хүн<br>“Хэмаб” 29 хүн<br>2025.03.13-14 “Үндэсний зөвлөгөөн” 61 хүн;<br>2025.03.24 “Гал унтраах дадлага сургалт” 56 хүн<br>2025.04.05 “Аюулгүй ажиллагааны соёлыг түгээе” 61 хүн;<br>2025.04.07 “Багын ажиллагаа, дунд шатны менежерүүдийн сургалт” 22 хүн<br>2025.04.24 “Стрессээ эергээр удирдах энгийн арга” 42 хүн;<br>2025.09.03 “Шинэ ажилтны баримжаа олгох сургалт”-д 6 хүн,<br>2025.09.05 “ChatGPT болон хэрэглээний AI” сургалтад 15 хүн;<br>2025.09.16 “Архив бичиг хэргийн сургалт” 50 хүн;<br>2025.09.25 Цус сэлбэлт судлалын сувилагчдын зөвлөгөөнд 70 хүн;<br>2025.10.24 Эрдэм шинжилгээний XII бага хурал 42 хүн; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025.11.20 Нэгдсэн менежментийн тогтолцоо, ерөнхий ойлголт сургалт 40 хүн;<br>2025.11.20 Галын хортой ажиллах зааварчилгаа сургалт 41 хүн<br>2025.12.11-12 Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан Яаралтай тусламжийн багц цагийн сургалтад мэргэжилтнүүдийг хамруулсан.<br>2025.12.09-нд Ёс зүйн зөвлөлтэй хамтран ёс зүйн сургалтыг зохион байгуулж нийт ажилчдыг хамруулсан. | |
| 52. | ЗГМХ 2.3.4.2 Эмнэлзүйн цус сэлбэлт судлал, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулна. | -Сургалт зохион байгуулах тушаал, -Сургалтад хамрагдсан суралцагчийн тоо | Цус сэлбэлт судлалын мэргэшүүлэх сургалтыг 2024 онд 2 удаа зохион байгуулсан | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | I-IV улирал | Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан.<br>2025 оны байдлаар ЭМС-ын А/250 дугаар тушаалаар нийт 7 эмч, 1 био-анагаахын мэргэжилтэн амжилттай суралцаж төгссөн ба 10 дугаар сараас эхлэн ЭМС-ын А/433 дугаар тушаалаар Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 3 их эмч элсэн суралцаж байна. | 100% |
| 53. | ЗГМХ 2.3.4.2 Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | -Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал -Сургалтад хамрагдсан хүний тоо | Цус сэлбэлт судлалын төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2024 онд 2 удаа зохион байгуулсан | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | I-IV улирал | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын тушаалын дагуу Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх" сургалтыг 2 удаа зохион байгуулан ажиллалаа.<br>2025 оны байдлаар: ЭМХТ-ийн захирлын А/113 дугаар тушаалаар 4 сувилагч амжилттай суралцаж төгссөн ба 10 дугаар сараас ЭМХТ-ийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/164-р тушаалаар Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 6 сувилагч элсэн суралцаж байна. | 100% |
| 54. | БСТЗ 4.1.1 Төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 6674:2017 стандартыг шинэчлэн боловсруулна. | -Шинэчлэн боловсруулсан стандартын төсөл -Хүргүүлсэн албан хүсэлт | ЦССҮТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS 6674:2017 стандартыг мөрддөг. | Төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 6674:2017 стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах саналыг хүргүүлсэн байна. | II-IV улирал | Төвийн захирлын 2025 оны 03 сарын 17-ны А/17 тушаалын нэгдүгээр хавсралтаар Төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 6674:2017 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон. Ажлын хэсэг 1 удаа хуралдаж хэрхэн өөрчлөх шинэчлэх талаар хэлэлцсэн. Цусны донорын тухай хуулийн төсөлтэй уялдуулан бүтэц дүрмээ шинэчлэхээр төлөвлөсөн. Хуулийн төсөл 2025 оны 12 сарын 23-ны байдлаар УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэгдэж байна. | 90% |
| 55. | БСТЗ 4.1.1 Дотоод аудит, дотоод хяналтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | -Төлөвлөгөө, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | Дотоод аудитын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | Дотоод аудитын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн байна. | I-IV улирал | Тус төв нь дотоод аудит, хяналт тойрон үзлэгийн хөтөлбөрийг дараах 4 чиглэлд хийхээр төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:<br>• Дотоод аудит 2 удаа,<br>• Дотоод хяналт 12 удаа,<br>• Удирдлагын тойрон үзлэг 2 удаа,<br>• ХЭМАБ-ын үзлэг 2 удаа тус тус хийгдэж, нийт 56 сайжруулах санал, зөвлөмжийг алба тасгуудад | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилт 100% | | | хүргүүлэн ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 88% байна. | |
| 56. | БСТЗ 4.1.1 Сувилахуйн тусламж үйлчилгээг төвийн онцлогт тохируулан төлөвлөн хэрэгжүүлнэ. | -Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Сувилахуйн албаны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн 100,0% биелсэн. | Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | СҮА-аас 4 зорилтын хүрээнд 12 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100% байна.<br>1. 18 албан бичиг ирсэн 15-д нь хариу өгсөн 3 хариугүй бичиг байна.<br>2. Албаны тэмдэглэл 12 ирсэн 8 хэрэгжүүлсэн 4 нь харах эрхтэй бичиг байна<br>3. Сувилахуйн төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад 12 сувилагч элссэн тойролтууд явагдаж байна.<br>4. ОУСӨ-ийг угтан “Сувилагч танаараа бахархъя” талархлын сарын аяны хүрээнд 7 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилт 96% байна үүнд:<br>- “Сувилагч танаараа бахархъя” хүндэтгэлийн арга хэмжээ<br>- “Сувилагч тандаа баярлалаа” өдөрлөг<br>- Талархлын 7хоног, сургалт, “Сувилагчаа сонсье” хайрцаг аялуулах, шинжилгээ “Сэргэг өглөө-Цэнгэг агаар” алхалт зэргийг төлөвлөн хэрэгжүүлсэн.<br>5. ИМҮ зохион байгуулах хуваарийн дагуу 3 тасагт зохион байгуулж 5 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан<br>6. ДЗБТ-ийн бүртгэгдсэн гуурс код, танин тодруулалттай холбоотой тохиолдол дээр хэлэлцүүлэгт 2 удаа хийж тасгийн 23 сувилагч оролцсон.<br>7. Алба танхимаар 5 удаа цахимаар 6 хуралдаж 8 үйл ажиллагааг ярилцаж шийдвэрлэсэн.<br>8. ISBT-ны санхүүжилтээр “Цусны албаны сувилагчдын үндэсний зөвлөгөөн-II“ 9 сард зохион байгуулсан.<br>9. Сувилагч нарт зөөлөн ур чадварын сургалтыг “Эерэг харах чадвар”, “Үе хоорондын ялгаа”, “Харилцан адилгүй зан чанар” зэрэг сэдвүүдээр 3 удаа орж давхардсан тоогоор 65 (67%) сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдсан байна.<br>10. Сувилагч мэргэшлийн зэргийн 2025 оны шалгалтад Зөвлөх 2, Тэргүүлэх 1, ахлах 1 сувилагч шалгалт аа амжилттай өгсөн. | 100% |
| 57. | БСТЗ 4.1.1 Халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | -Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2024 онд 2 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөн 97,3% хэрэгжүүлсэн. Эмнэлгийн, тусламж үйлчилгээтэй холбоотой | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлж ажилласан байна. | I-IV улирал | 2025 онд ХСХ-ын чиглэлээр 4 зорилтын хүрээнд нийт 15 ажил хийхээр төлөвлөгөө боловсруулан захирлаар батлуулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. 2025 онд нийт 6 гэрээг 25,203,500 төгрөгний гэрээ байгуулж халдварын сэргийлэлт хяналтад шаардлагатай бараа материалын нөөцийг бүрдүүлж ажилласан. Ажлын байранд гар угаах сургалт, гар угаах 5 мөч, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх тайлах дараалал, өртөлтийн дараах сэргийлэлтийн цомог ашиглах, асгарсан цацагдсан биологийн шингэн цэвэрлэх иж бүрдэлийг хэрхэн ашиглах,шинэ ажилтанг чиглүүлэх сургалт, цэвэрлэгээ болон хог хаягдлын менежментээр нийт 11 удаа сургалт зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | халдвар гараагүй. | | | байгуулж давхардсан тоогоор 68 эмч, эмнэлгийн ажилтанг сургалтад хамруулсан. Улаанбурхан, улаануудын эсрэг дархлаажуулалтанд нийт 40 ажилтныг хамруулсан. Үүнд: эмч 5, сувилагч 16, үйлчлэгч 1, бусад ажилтан 17 байна. Улаанбурхан улаануудын эсрэг вакцины хамралтын хувь нь эмч 92%, сувилагч 89% үйлчлэгч 100%, бусад 100% дархлаажуулалтад хамрагдсан. Нийт ажилтны 93% дархлаажуулалтад хамрагдсан. В-гийн дархлал тогтоцыг үзэж 2025 онд 26 ажилтанг хамруусан. Нийт ажиллагсдын 91%-г дархлаажуулалтанд хамруулсан. Төвийн 1,2 байранд 2233.2 м2 талбайд “Улаанбаатар ариутгал” ХХК-р шавьж, мэрэгчгүйтгэл хийлгэсэн.<br>Нийт ажиллагсдын урьдчилан сэргийлэх үзлэгийг 2025 оны Хавдар судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж, 2025 оны 12-р сарын 13-нд бүх ажилчдыг хамруулсан. | |
| 58. | БСТЗ 4.1.2 Тогтмол гаргадаг статистик үзүүлэлт, тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж холбогдох албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангана. | Үндсэн үйл ажиллагааны өдөр тутмын тоон мэдээ, сарын статистик үзүүлэлт, тайлан | Сар бүр статистик үзүүлэлт гарган дүн шинжилгээ хийж танилцуулдаг. Өдөр тутам үндсэн үйл ажиллагааны тоон мэдээ гаргаж мэдээлдэг. Цусны албаны тайланг нэгтгэн тайлагнадаг. | Тогтмол гардаг статистик үзүүлэлт, тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж холбогдох албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан байна. Тайланг нэгтгэж цаг хугацаанд нь тайлагнасан байна. | I-IV улирал | 2024 оны 12 сарын 30-ны өдөр ЭМХТ-өөс ирүүлсэн 1388 тоот албан бичгийн дагуу ЦССҮТ болон Цусны албаны 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 308 тайлангийн маягтаар гарган, 2025 оны 01 сарын 16-ны өдөр ЦССҮТ-ийн тайланг, 2025 оны 02 сарын 01-ний өдөр Цусны албаны тайланг тус тус хүлээлгэн өгсөн.<br><br>2025 оны 05 сарын 26-ний өдөр ЭМХТ-өөс ирүүлсэн 535 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, ЭМЯ-аас үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувийн эмнэлгүүдийн 2024 оны жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээгээр 90 (А) үнэлгээ авсан.<br><br>-2025 оны 03 сарын 14-15 өдрүүдэд зохион байгуулагдсан “Цусны албаны Үндэсний зөвлөгөөн”-д ЦСТ-үүдийг шаардлагатай статистикийн мэдээллээр хангаж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.<br><br>-ЭМХТ-өөс эрхлэн гаргадаг “Эрүүл мэндийн үзүүлэлт-2024” эмхэтгэлд 1. Цусны донор элсүүлэлт, алдаршуулалт, урамшуулалт 2.Цус, цусан бүтээгдэхүүний хангалт 3. Цус сэлбэлт судлалын салбарын лабораторийн тусламж үйлчилгээ 4. Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ 5. Цусны салбар төвүүдийн үйл ажиллагаа сэдвээр нийт 5 бүлэг бүхий 8 нүүр мэдээлэл бэлтгэн хэвлүүлсэн.<br><br>-Сар бүрийн эхний 7 хонгийн эмч, мэргэжилтнүүдийн шуурхай хуралд өмнөх сарын статистик /үйлдвэрлэл болон борлуулатын/ мэдээллийг боловсруулан танилцуулж, мэдээллээр хангадаг. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Өдөр бүр цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн мэдээг бэлтгэн төвийн фэйсбүүк группт байршуулан эмч, мэргэжилтнүүдийг мэдээллээр хангаж ажилласан.<br>-Сар бүр Нийслэлийн статистикийн газарт “АҮ1-маягт” батлагдсан маягтын дагуу ЦССҮТ-ийн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээг Нийслэлийн статистикийн газрын программд шивдэг. | |
| 59. | БСТЗ 4.1.2 Монгол Улсын Цусны албаны статистик үзүүлэлтийн эргэн мэдээллийн эмхэтгэл гаргаж түгээнэ. | Бэлтгэж гаргасан эмхэтгэл, тараасан тоо | ЭМХТ-ийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлд нэг бүлэг мэдээлэл гардаг. Цусны алба 2023 эмхэтгэл хэвлэгдсэн. | Монгол Улсын Цусны албаны 2024 эмхэтгэл хэвлэгдсэн байна. | I-II улирал | Цус сэлбэлт судлалын салбар-2024 эмхэтгэл бэлтгэн 100ш хэвлүүлсэн. Эмхэтгэлийг “Цусны албаны Үндэсний зөвлөгөөн”-д орон нутгийн ЦСТ-өөс оролцсон эмч мэргэжилтэн, ЭМЯ-ны мэргэжилтэн, илтгэл хэлэлцүүлсэн УНТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ-ийн эмч мэргэжилтэнд олгосон. Цусны донорын тухай хуулийн төслийн танилцуулга, Нийгмийн бодлогын Байнгын хороо, УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан УИХ, байнгын хорооны гишүүд төвийн үйл ажиллагаатай танилцах үеэр тарааж мэдээллээр хангасан. Төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч, эмч мэргэжилтнүүд, ЦДДӨ-ийг тохиолдуулан ЭМЯ-ны харьяа ЭМБ-ын удирдлагуудад түгээж, мэдээллээр хангаж ажилласан. | 100% |
| 60. | БСТЗ 4.1.3 Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | -Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь -Аудитын дүгнэлт | 2023 оны аудитын дүгнэлтээр өөрчлөлтгүй дүгнэлт авсан. Аудитаас өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, өөрчлөлтгүй дүгнэлт авсан байна. | I-IV улирал | 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” үнэлгээ авч, 2 албан шаардлага, 2 зөвлөмж авч өмнөх оноос тоо хэмжээг бууруулан, актгүй ажилласан. Дээрх алдаа зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган байгууллагын удирдлагаар батлуулан хэрэгжүүлэн ажилласан бөгөөд Үндэсний аудитын газар болон санхүүгийн тайлангийн аудит хийсэн Баян суварга ХХК-д биелэлтийг албан бичигтэйгээр цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэн ажилласан. Одоогийн байдлаар fas.audit.mn цахим системд оруулсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт Үндэсний аудитын газрын эхний үе шатны хяналтаар 100 хувьтай байна.<br>Санхүүгийн бүртгэлийн ажиллагааг сайжруулах 21 заалттай төлөвлөгөө болон Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 93% байна. | 100% |
| 61. | БСТЗ 4.1.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, баталгаажуулалтыг хийлгэж, хэвийн үйл ажиллагааг хангана. | -Шалгалт тохируулга, баталгаажуулалтын гэрчилгээ -Засвар үйлчилгээний төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | 2024 онд тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 8, багаж хэрэгслийн шалгалт тохируулга 52 удаа хийлгэсэн. Эмнэлгийн тоног төхөөрөмжид 32 удаагийн төлөвлөгөөт | Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүрэн хийлгэж гэрчилгээ авсан байна. Тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон өдөр тутмын засвар үйлчилгээг хийж төвийн үндсэн үйл ажиллагааны | I-IV улирал | Монгол Улсын Шадар Сайдын 2015 оны 117 дугаартай ‘’ Хэмжил зүйн ажил, үйлчилгээний хэмжээг шинэчлэн батлах тухай’’ тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дугаартай ‘’ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх’’ журмын дагуу төвийн хэмжээнд ашиглагдаж байгаа Электрон жин-31, Пепитика-12 механик даралтыг аппарат-5 нийт 48 ширхэг хэмжих хэрэгсэлийг мэргэжлийн байгууллагаар жилд 1 удаа шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэж. СХГ-аар шалгалт тохируулга, баталгаажилтын 48 багаж хэрэгслийг гэрчилгээжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ хийсэн. Хэрэгжилтийн хувь 90.5% | тасралтгүй байдлыг хангасан байна. | | Тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ:<br>1. Сүхбаатар цус цуглуулах төвийн -30 хүйтэн өрөөний засварыг Хөргөлт инженеринг ХХК-аар дотор сэнс солих, гадна мотор нь дээр засвар хийх тос масло солих, хөргөлтийн фреон шахах, засвар үйлчилгээ хийлгэсэн.<br>2.Hiscl-5000 аппарат дээр солигдох шаардлагатай сэлбэг хэрэгслийг Пролианс ХХК-аар засвар үйлчилгээ хийлгэсэн.<br>3.Баянзүрх цус цуглуулах төвийн +2+8 хүйтэн өрөөний гадна моторын шугам цоорсныг Хөргөлт инженеринг ХХК-аар засвар хийлгэж фреон шахуулж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.<br>4.PCS аппаратны line sensor худалдан авч шинээр сольж, тохиргоо засвар үйлчилгээ хийсэн.<br>5. Сүхбаатар цус цуглуулах төвийн pcs аппаратны дэлгэцийн уян кабель худалдан авч шинээр сольж засвар үйлчилгээ хийсэн.<br><br>Тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ:<br>1. Баянзүрх цус цуглуулах төвийн бүтээгдэхүүн олгох хэсгийн өрөөний TCL эйр кондишн гадна мотор ажиллахгүй зогсож Хөргөлт инженеринг ХХК-аар яаралтай засвар үйлчилгээ хийлгэж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.<br>2. Үйлдвэрлэлийн тасгийн INT-100 illuminator аппарат нь дээр тэжээлийн блок нь дээр гэмтэл гарч, тоног төхөөрөмжийг ханган нийлүүлсэн Интерсайнс ХХК-аар тэжээлийн блок засвар үйлчилгээ хийлгэж мөн агаар мэдрэгч дээр тохиргоо хийлгэсэн. | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: [signature] Ч.БАТБОЛД, ЗАХИРГАА, МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА